

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО: ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦСЭН ГЭМТЭЛ СОГОГИЙН ЦОГЦ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРСДЭЛГҮЙ ЭЭЛТЭЙ ОРЧИНД ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ ҮЗҮҮЛНЭ.							
Зорилт 1. Гэмтэл согогын цогц тусламж ,үйлчилгээг олон улсын удирдамж, стандартын дагуу үзүүлэх.							
1.1	Спортын гэмтлийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны ЭМСайдын тушаалаар байгууллагын шинэ бүтэц чиг үүрэгт Спортын гэмтлийн төвийн бүтэц орон тоо батлагдсан.	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байна.	Спортын гэмтлийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд 4 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. 2024 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 100 %-ийн үзүүлэлттэй байна.	100%
1.2	Нөхөн сэргээх эмчилгээг цогцоор үзүүлэх нэгжийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны ЭМСайдын тушаалаар байгууллагын шинэ бүтэц чиг үүрэгт Нөхөн сэргээх мэс заслын тасгийн орон тоо батлагдсан .	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байна.	Нөхөн сэргээх эмчилгээг цогцоор үзүүлэх нэгжийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд 6 зорилтын хүрээнд 21 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. 2024 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 100 %-ийн үзүүлэлттэй байна.	100%
1.3	Сэргээн засах эмчилгээний чанар	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Салбар эмнэлэгт 20 ортой хэвтүүлэн	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байна.	1.Төв эмнэлэгт нийт 9506, үүнээс амбулаторийн эмчийн үзлэг-5730, стационарт 3776 үйлчлүүлэгчид	100%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	хүртээмжийг нэмэгдүүлнэ .			эмчлэх тасгийг нээж үйл ажиллагааг эхлүүлсэн. Сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн.		үзлэг оношлигоо хийж үйлчилсэн байна. Энэ нь жилийн өмнөх мөн үетэй харьцуулахад нийт үйлчлүүлэгчдийн тоо 19,8%-аар өссөн байна. Үүнээс амбулаторийн эмчийн үзлэгийн тоо өмнөх жилээс 2,4%-аар буурч, стационарын үзлэгийн тоо 54,6% өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь тасагт хэвтэн эмчлүүлж буй цочмог гэмтлийн үеийн сэргээн засах эмчилгээний чанар сайжирч, нөгөөтэйгөөр амбулаториор өдрийн эмчилгээний стор нээдэг болсонтой холбоотой амбулаторийн үзлэгийн тоо буурсан гэж үзэж байна. Эмчилгээний нэр төрлийн хувьд: Хөдөлгөөн засал –40748 удаа Hot pack – 10864 удаа Цахилгаан эмчилгээ – 50448 удаа Хөдөлмөр засал-11626 удаа хийж гүйцэтгэсэн байна. 2. Салбар эмнэлэгт нийт 5248, хэвтэн тасагт 494, амбулаторийн эмчийн үзлэг 2983, бусад 6 тасгийн 1771 хэвтэн эмчлүүлэгчид үзлэг оношилигоо	

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						хийж үйлчилсэн байна. Үүнээс сэргээн засах эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлэгчийн тоо 494 байгаагаас 0-18 насны хүүхэд 23, амбулаториор 2983 байгаагаас 0-18 насны хүүхэд 899 байна. Энэ нь жилийн өмнөх мөн үетэй харьцуулахад тасгийн хэвтэн эмчлүүлэгчийн тоо, амбулаторийн эмчлүүлэгчийн тоо 80% өссөн байна. Нийт амбулатори болон хэвтэн эмчлүүлэх 6 тасагт сэргээн засах эмчилгээ, тусламж үйлчилгээг үзүүлсэн бөгөөд эмчилгээний нэр төрлийн хувьд: Хөдөлгөөн засал – 11120 удаа Парафин – 1384 удаа Жин эмчилгээ – 2523 Цахилгаан эмчилгээ – 26412 Хөдөлмөр засал – 4217 удаа хийж гүйцэтгэсэн байна.	
1.4	MNS 7101:2023 Эрүүл мэндийн байгууллагын чанарын менежментийн тогтолцоо, шаардлага	45.0	MNS 7101:2023 стандартын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 онд MNS 9001:2015 стандартыг хэрэгжүүлэгч байгууллага болсон.	Төв эмнэлэгт MNS 7101:2023 Эрүүл мэндийн байгууллагын чанарын менежментийн тогтолцоог	MNS7101:2023 Эрүүл мэндийн байгууллагын чанарын менежментийн тогтолцоо, шаардлага стандартын сургалтад 2 мэргэжилтэн хамрагдаж гэрчилгээ авсан байна. .	100%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана.				хэрэгжүүлэх төлөвлөгөө бүрэн биелсэн байна.	“Аму консалтинг ХХК”-р төвийн хэмжээнд 7101:2023 стандартын зөрүүний дүн шинжилгээг хийлгэж 06 сарын 17 ажилчдын дунд хурлыг зохион байгуулан дүгнэлтийг танилцуулсан. 7101:2023 Эрүүл мэндийн байгууллагын чанарын менежментийн тогтолцоо шаардлага стандартыг хэрэгжүүлэх гэрээг 2023.06.14 “Аму консалтинг” ХХК-тай байгуулж тус стандартын танилцуулга хичээлийг төвийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.	
1.5	Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO/IEC:2015:2013-ийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг боловсруулан ажиллана.	2.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 онд мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тоног төхөөрөмжийн худалдан авалт хийгдсэн.	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байна.	2024 оны 8 сард мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн ба зөвлөмжийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. ISO/IEC:2015 ийг нэвтрүүлэх төлөвлөгөөг гаргаж төлөвлөгөөний дагуу “System center” ххк-тай хамтран гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна.	100%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1.6	Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага “MNS 7014:2023” стандартыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага “MNS 7014:2023” стандартыг нийт эмч эмнэлгийн ажилтанд танилцуулах 5 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан.	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байна.	ГССҮТ-н Захирлын 2024.01.22 А/17 тоот тушаалаар төв болон салбар эмнэлгийн хэмжээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2015 стандартыг хэрэгжүүлэх ажлын хэсэг”, 2023.12.26 А/161 тоот тушаалаар “Үйлчлүүлэгчийн дэмжих орон тооны бус зөвлөл” тус тус байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хүрээнд төв болон салбар эмнэлэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан нэгдсэн ГССҮТ-н эмнэлгийн хэмжээний төлөвлөгөө боловсруулан төвийн захирлаар батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллаа. MNS 7014:2023 стандартын “Эмнэлгийн ажилтан бүр хөтөч” аяныг 2024.04.01-06.01 хооронд зохион байгуулж, Төв болон Салбар эмнэлэгт Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандартын танилцуулга хичээл, шинээр ажилд орсон нийт 197 эмч, ажилтан мөн 25 резидент эмч нарт шинэ ажилтны чиглүүлэх	100 %

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						сургалтыг зохион байгуулсан. Мөн ГССҮТ-н захирлын 2023.11.08 А/130 тоот тушаал ГССҮТ-н гадна, дотно хаягжилтын ажлын хэсэг байгуулан үйл ажиллагааг 2 дугаар улиралд 100% гүйцэтгэн ажилласан.	
1.7	Нотолгоонд суурилсан мэс заслын, эмчилгээний шинэ дэвшилтэд технологи нэвтрүүлнэ.	-	Нэвтрүүлсэн мэс заслын тоо	2023 онд нийт 2 мэс засал шинээр хийсэн.	4-өөс доошгүй мэс засал, эмчилгээ шинэ технологи нэвтрүүлсэн байна.	1.Мөр эргүүлэгч шөрмөсний сэргээх боломжгүй урагдалд гуяны шөрмөсөөр нөхөн сэргээх дурангийн мэс засал 2.Ясны хорт хавдартай хэсгийг бүрэн авч, хиймэл яс үе суулгах мэс засал 3.Шагайн дурангийн мэс засал 4.Мөрний үеийг бүтэн солих мэс засал 5.Тохойн үе, атгаал ясны дутмагшлыг нийлмэл хиймэл үеэр (мегапротез) солих мэс засал 6.Үений гадаргуу мөгөөрсийг шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээг амжилттай нэвтрүүлсэн байна.	100%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1.8	Өндөр даралтын хүчилтөрөгч /Барокамер/-ийн эмчилгээ нэвтрүүлнэ.	-	Эмчилгээнд хамрагдсан хүний тоо	Салбар эмнэлэг Барокамерийн тоног төхөөрөмж суурилагдсан.	Өндөр даралтын хүчилтөрөгч /Барокамер/-ийн эмчилгээ хийж тогтмолжсон байна.	Өндөр даралтат хүчилтөрөгчийн эмчилгээг тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх үүднээс есдүгээр сарын 1-ний өдрөөс Тайваний “Tri-Service” эмнэлгийн M.D. PhD Shan Yueh Chang болон M.D. PhD Chih-hao Shen тэргүүтэй эмч, сувилагч нарын бүрэлдэхүүнтэй 2 баг Монголд ирж ажиллан, эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх орчин үеийн дэвшилтэт технологийн зааварчилгаа, эмчилгээний арга зүйн талаарх ажлын байрны сургалтыг зохион байгуулсан. Тус төвийн салбар эмнэлэгт суурилуулсан энэхүү төхөөрөмжийг хэрхэн ашиглах, эмчилгээний явц болон үр дүнд хяналт хийх, аюулгүй ажиллагааг бүрдүүлэх, үйлчлүүлэгчдэд үзүүлэх тусламж үйлчилгээний заавар, журмын талаарх сургалтад ГССҮТ-ийн эмч, сувилагч, техникч зэрэг нийт 18 ажилтан хамрагдсан. 2024.09.11-нээс эхлэн үйлчлүүлэгчийг тус эмчилгээнд хамруулж байна. Сарын	100 %

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						хугацаанд 31 хүн хамрагдаж үүнээс 1 хүн хамгийн ихдээ 16 удаагийн давтамжтай орсон бол дундаж оролт нь 10 удаагийн давтамжтай байна. Өдөрт 5 хүн дунджаар өндөр даралтат /барокамер/-ийн эмчилгээнд хамруулж байна.	
1.9	Өсвөр насны шалтгаан тодорхойгүй мурийлтын үеийн эвийн эмчилгээний аргыг сайжруулна.	-	Эмчилсэн хүний тоо	Нурууны мурийлтын үед хөдөлгөөн заслын эмчилгээ болон мэс заслыг хийж байна.	Нурууны мурийлтын үеийн эвийн эмчилгээнд Brace ашигладаг болсон байна.	ГССҮТөвийн Сэргээн засах эмчилгээний тасаг болон Нурууны мэс заслын тасаг хамтран “Солонго Эс Эф” бүрэн дунд сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдын дунд нурууны мурийлтыг эрт илрүүлэх үзлэгийг зохион байгууллаа. Үзлэгт 161 сурагч хамрагдсанаас 40,37% нь хөнгөнөөс дунд зэргийн нурууны мурийлттай гэж оношлогдлоо. Үзлэгээр өөрчлөлттэй гарсан хүүхдүүдийг ГССҮТ дээр нурууны мурийлтын нарийвчилсан үзлэг хийж, рентген зураг авч оношийг баталгаажуулсан. Үзлэгийн дунд мурийлтын өнцгийг тодорхойлоход 8-20 градус мурийлттай буюу нурууны мурийлтын хөнгөнөөс дунд	50%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						зэргийн өөрчлөлттэй гарсан. Хөнгөн зэргийн нурууны муруйлттай сурагчдад зөвлөгөө өгч, тогтмол хянуулж байхыг зөвлөсөн бол дунд зэргийн муруйлттай сурагчдыг сэргээн засах эмчилгээнд явахыг зөвлөв.Тус үзлэгээр нурууны муруйлтын үеийн эвийн эмчилгээ Brace эмчилгээ шаардлагатай хүүхэд илрээгүй болно. ГССҮТөв нь Нийслэл “РОТАРИ” клубтэй хамтран Brace үйлдвэрлэх үйлдвэрийн санхүүжилтийг шийдвэрлэсэн боловч эмч мэргэжилтнийг сургалтад хамруулах хугацаанд гарах зардлыг шийдвэрлэж чадаагүй улмаас тус үйл ажиллагаа хойшлогдсон байна.	
1.10	Хавсарсан өвдөлт намдаах аргыг ашиглан мэс заслын дараах өвдөлт намдаалтыг сайжруулна.	-	Үйлчлүүлсэн хүний тоо	Төвийн хэмжээнд эмийн эмчилгээ болон судсанд өвчин намдаах памп ашиглан өвдөлт намдаалт хийж байна. -	Мэс заслын дараах өвчин намдаалтыг сайжруулж хавсарсан өвдөлт намдаах аргыг эмчилгээнд тогтмол хэрэглэдэг болсон байна.	2024 эмийн худалдан авалтад өвдөлт намдаах гуурсыг нэмэлтээр оруулж нийт 129 томоохон мэс заслын дараах өвчтөнд өвдөлт намдаах гуурсыг ашиглан эмчилгээ хийлээ. Тус эмчилгээний үр дүнд мэс заслын дараах хурц өвдөлтийг 2-3 хоног намдсан байна.	100%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1.11	Ясны хавдрын оношилогоо эмчилгээг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлнэ.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны ЭМСайдын тушаалаар байгууллагын шинэ бүтэц чиг үүрэгт Ясны эмгэгийн мэс заслын тасгийн орон тоо батлагдсан .	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байна.	Ясны хавдрын оношилгоо эмчилгээг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт 27 арга хэмжээний хүрээнд төлөвлөж хэрэгжилт 100%-ийн үзүүлэлттэй байна. . Ясны эмгэгийн мэс заслын тасаг нь доод мөчдийн ясны эмгэг болон төрөлхийн согог, ясны хавдартай үйлчлүүлэгчдэд мэс заслын болон сэргээн засах тусламж үйлчилгээг олон улсын түвшинд үзүүлж байгаа юм.Ясны хортой хавдрын үеийн хавдрыг бүрэн авч яс орлуулах хиймэл үеэр солих мэс заслыг БНСУын Korea Cancer center hospital-Department of Orthopaedic surgery эмнэлгийн тасгийн эрхлэгчCho Wan Hyeong-тэй хамтран хийсэн.	100%
1.12	Тусламж үйлчилгээнд шаардлагатай орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлнэ.	1.000.0	Нэмэгдүүлсэн тоног төхөөрөмжийн тоо	2023 онд дэвшилтэт тоног төхөөрөмжийн тоог 2-оор нэмэгдүүлсэн байна. Үүнд: Нурууны мэс заслын “CON	Орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжийн тоог 2-оос доошгүй нэмэгдүүлсэн байна.	Төвийн хэмжээнд тайлант онд тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологийн 5 төрлийн 7 ширхэг тоног төхөөрөмжийг худалдан авсан. Үүнд: -Мэс заслын өрөөний рентген харалтын аппарат C-ARM -3ш	100%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
				MED 4K UHD” нурууны дурангийн аппарат, Үений мэс заслын Arthrex Sunergy 4K дурангийн аппарат		-Зүрхний эхо аппарат 1ш -Ясны сийрэгжилтийн зөөврийн аппарат 1ш -Хөлийн тавхайн оношилгооны аппарат 1ш -Өвчтөний хяналтын монитор шалгах стимулятор 1ш	
1.13	Сувилагч нарын “мэргэжлийн ур чадвар”-т чадамжийн үнэлгээ хийнэ.	-	Үнэлгээний тайлан	Сувилагч нарын ур чадварт чадамжийн үнэлгээ хийгдээгүй байна.	Сувилагч нарын ур чадварын үнэлгээний шалгуур үзүүлэлт боловсруулж үнэлгээ хийгдсэн байна.	Эрүүл мэндийн хөгжлийн төв болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтарсан төслийн хүрээнд Сувилагч мэргэжилтний хөгжил, ур чадварын түвшинг тодорхойлох, жишиг эмнэлгүүдийн нэг тул, энэ ажлын хүрээнд ажлын хэсэг байгуулан Сувилагч нарын “Мэргэжлийн ур чадвар”-т чадамжийн үнэлгээ хийх ажлын хүрээнд удирдамж, төлөвлөгөө N1-N5 түвшний шалгуур хуудас боловсруулж төвийн захирлаар батлуулсан.	80%
ЗОРИЛТ 2:ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БОЛОН АЖИЛЧДАД ЭРСДЭЛГҮЙ,ЭЭЛТЭЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ							
2.1	Төвийн хэмжээнд ажлын байран дахь эмнэлзүй болон эмнэлзүйн бус	-	Эрсдэлийн хувь	2023 онд төвийн хэмжээнд эмнэлзүй болон эмнэлзүйн бус 449 эрсдэл	Эрсдэлийн үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээ авч өндөр эрсдэлтэй тохиолдлыг 10-аас	Төв эмнэлгийн хэмжээнд 2024 онд эмнэлзүйн болон эмнэлзүйн бус нийт 529 эрсдэл бүртгэгдсэнээс өндөр буюу улаан	100%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	эрсдэлийг бууруулна.			бүртгэгдсэн.Үүнэ эс өндөр эрсдэлтэй 95 тохиолдол бүртгэгдсэн энэ нь нийт тохиолдлын 21% -ийг эзэлж байна.	доошгүй хувиар бууруулсан байна.	эрсдэл 101 буюу нийт эрсдэлийн 19.1%-г эзэлсэн байна. Бүртгэгдсэн эрсдэлийг боломжид чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөөг гаргаж хэрэгжилтийг тогтмол үнэлж, үр дүнг тооцож ажиллаж байна. Үүнээс өндөр эрсдэлийн биелэлтийн хувь 15.8% буюу нийт эрсдэлийн биелэлтийн хувь 39.5% байна.	
2.2	ЭМС-ын 2023 оны 03 дугаар албан даалгавар, Кибер аюулгүй байдлын нийтлэг журамд үндэслэн дотоод болон гадаад сүлжээний аудит, эрсдлийн үнэлгээ хийлгэнэ.	20.0	Үнэлгээний тайлан Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	2023 онд төвийн галт хана дотоод сүлжээний төхөөрөмжийг шинээр сольж суурилуулсан ба дээрх төхөөрөмжүүдийг МАБ-н газарт шалгуулан зөвлөмжийн дагуу үйл ажиллагаанд нэвтрүүлсэн ба байгууллагад эрсдэлийн үнэлгээ, дотоод аудит хийгдээгүй.	Мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрсдэлийн үнэлгээ хийгдэж зөвлөмжийн дагуу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	2024-05 дугаар сард тус төвд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийгдсэн ба Тагнуулын ерөнхий газрын мэдээллийн аюулгүй байдлын газар нь 2024-06 сард зөвлөмжийг ирүүлсэн байна. Зөвлөмжийн хүрээнд хийгдсэн ажлын тайланг нэгтгэн хүргүүлсэн ба үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	100 %

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
2.3	Гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлөвлөлтөд оролцох, сэдэвчилсэн болон үзүүлэх сургалт зохион байгуулах, төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ биелүүлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.	5.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Ерөнхий захирлын 2023 оны 05 дугаар сарын 22-ны А/83 тоот тушаалаар Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг шинэчлэн Стратегийн команд штабын бэлэн байдлын сургуулилтыг 2023 оны 06 сарын 07-09 ны хооронд зохион байгуулсан. Үүнд: Төвийн болон салбар эмнэлгийн шаардлагатай үйл ажиллагааны төлөвлөгөө болон нөөцийг гарган ажилласан.	Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авч ажилласан байна.	Улсын онцгой комиссын 2024 оны 01 албан даалгаврын хүрээнд Болзошгүй үерийн үед ажиллах хүч,техник,тоног төхөөрөмж,эм,эмнэлгийн хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах нөөцийг бүрдүүлэх,үерийн дараа үүсэж болзошгүй халдварт өвчний эрсдэлийн үнэлгээг хийх,урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч,иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг түгээх,ариутгал халдваргүйтгэл хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж хэрэгжилтийг тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн. ОБЕГ-аас 3 дугаар сарын 28-ны өдөр улсын хэмжээнд зохион байгуулсан гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилтад Гэмтэл согог судлалын үндэсний төв болон салбар эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, албан хаагчид идэвхтэй хамрагдлаа.	100%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвөөс улс орон даяар зарлан мэдээллийн дохиог гурван удаа дамжуулсан бөгөөд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, хэвтэн эмчлүүлэгчид өөрт ойр байгаа аюулгүйн цугларах талбайд гарч, дадлага сургуулилтад оролцсон юм.	
2.4	Хэвтэн эмчлүүлэх 1 тасгийн корпусыг бүрэн засварлана.	390.0	Үйлчлүүлэгч болон эмч ажилчдын орчин нөхцөл сайжирсан байна.	2023 онд хэвтэн эмчлүүлэх 2 тасгийг бүрэн засварлаж орчин нөхцөлийг сайжруулсан.	Төвийн өмнөх онд завсар хийгдээгүй Хэвтэн эмчлүүлэх 1 тасгийг бүрэн засвар-лан үйлчлүүлэгч болон ажилчдын орчин нөх-цөл сайжирсан байна.	Төвийн хэмжээнд хэвтэн эмчлүүлэх нийт 70 ор бүхий Нурууны мэс заслын тасаг болон Хавсарсан гэмтлийн мэс заслын 2 тасгийг бүрэн засварлалаа.	100%
2.5	Нөөц үүсгүүрийн бэлэн байдлыг хангана.	95.0	Төвийн эрчим хүчний нөөц үүсгүүрийн автомат сэлгэн залгах бэлэн байдал хангагдана.	2022 онд шинэ 800 квт хүчин чадалтай нөөц үүсгүүрийг суурилуулан үндсэн холболт хийгдсэн. Нөөц үүсгүүрийн автомат сэлгэлт хийх холболт	Төвийн эрчим хүчний 100% хангах хүчин чадалтай нөөц үүсгүүрийн бэлэн байдал хангагдаж автомат сэргэн залгалт хийгддэг болсон байна.	Төвийн эрчим хүчний нөөц үүсгүүрийн автомат сэлгэн залгах бэлэн байдал хангах ажлын хүрээнд тендер зарлаж гүйцэтгэгчээр “Стар энерги сервис” ХХК шалгарсан. Төвийн цахилгааны гадна ТП тоноглол шинэчлэх,нөөц үүсгүүрийн бэлэн байдал	100 %

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
				хийгдээгүй байна.		хангагдаж автомат сэргэн залгалт хийгддэг болсон.	
2.6	Нисдэг тэрэгний талбайг стандартын дагуу өргөтгөн засварлана.	60.0	Стандартад нийцсэн нисдэг тэрэг буух талбайтай болсон байна..	МУ-ийн Аэродром, Хелипортод тавих шаардлага MNS 6784:2019 стандарт, Иргэний нисэхийн ерөнхий газрын НААХЗАлбаны дүгнэлтээр төвийн нисдэг тэрэгний талбайг ашиглах боломжгүй дүгнэлт гарсан.	Нисдэг тэрэг буух аюулгүй байдлыг хангасан стандарт талбайтай болсон байна.	МУ-ийн Аэродром, Хелипортод тавих шаардлага MNS 6784:2019 стандарт заасан хелипортыг байгуулахад төлөвлөсөн талбайн хэмжээ шаардлагад нийцээгүй тул хийгдээгүй байна. Гэмтэл согогийн тусламж үйлчилгээ шаардлагтай үйлчлүүлэгчийг нисдэг тэргээр зөөвөрлөж тусламж үйлчилгээг цаг алдалгүй шуурхай үзүүлж байна. 2024 онд орон нутгаас нийт 32 удаа төвийн нисдэг тэрэгний талбайд өвчтөн тээвэрлэж ирсэн онгоц буулт хийсэн байна.	0%
2.7	Камерын нэгдсэн системийн холболт, эмнэлгийн камер суурилуулалт хяналтын тогтолцоог сайжруулна.	15.0	Бичлэгийн хугацаа уртассан камерын тоо	Төвийн хэмжээнд 100 орчим эмнэлгийн болон цагдаагийн ерөнхий газрын камер ажиллаж байна. Нэгдсэн хяналтын систем	Камерын бичлэг хадгалах хугацааг уртасгаж, нэгдсэн системд холбогдсон байна.	Камерын нэгдсэн системийн хяналт гүйцэтгэх систем бүрэн нэвтэрч мэдээлэл технологийн албаны өрөө болон бусад шаардлагатай газруудаар нэмэлт камерууд байршиж Төвийн хэмжээнд нийт 105 камер 30 буюу түүнээс дээш хоног хадгалах	100%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
				дутмаг, хадгалах хугацаа богино.		шаардлагыг хангаж хэвийн ажиллаж байна.	
2.8	Антибиотикийн бодлого боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллах, эмнэлгийн орчинд нян ба антибиотикт тэсвэрт чанарын судалгааг хийж эмч нарт танилцуулна.	-	Судалгааны тайлан	Антибиотикийн дэд хорооны төлөвлөгөөг боловсруулан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг бууруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээнд антибиотикийн хэрэглээний судалгааг хийсэн байна.	2024 оны 05 сараас ГССҮТөвийн ЯЭМЗТасагт хэвтэн эмчлүүлж мэс засал хийгдсэн 200 үйлчлүүлэгчид гадаад орны 7 эмнэлгийн удирдамжийг ашиглан антибиотик эмчилгээг хийж судалгаа хийгдсэн. Судалгааны үр дүнг боловсруулж байна.	70%
2.9	Шинэ болон сэргэж буй халдварт өвчин, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, бууруулах арга хэмжээг зохион байгуулж тандалт судалгааг хийнэ.	4.0	Илрүүлэг, хариу арга хэмжээ авсан тоо. ЭТҮХХ-ийн хувь.	15399 үйлчлүүлэгчээс Гадны шалтгаант-70,9% ЭТҮХХ-20,8% Халдварын шалтгаан тодорхойгүй - 8,3%. Ковидын хэвтэн эмчлүүлсэн 183 тохиолдолд тусламж	ЭТҮХХ-ыг 10%-р бууруулсан байна.	Төвийн нийт 19446 хэвтэн эмчлүүлэгчдээс MRSA халдвартай-613, Acinetobacter baumannii халдвартай-177, Pseudomonas aeruginosa халдвартай-65, Klebsiella pneumoniae-163, үйлчлүүлэгч сэрэмжлэх нянгийн халдвартай, Салбар MRSA халдвартай-613, Acinetobacter baumannii халдвартай-215, Pseudomonas aeruginosa халдвартай-217, Klebsiella pneumoniae-64	80%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
				үйлчилгээ үзүүлж, тандалт судалгаа хийсэн.		үйлчлүүлэгч сэрэмжлэх нянгийн халдвартай. Төвийн 493, салбар 484 эмчлүүлэгчдийн тандалтын хуудсанд тандалт хийхэд нийт тохиолдлын 67,8% нь гадаад шалтгаант халдвар 13,7% нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой дотоод халдвар 18,5% нь шалтгаан тодорхойгүй халдвар байна. Шинэ болон сэргэж буй халдварт өвчин, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, бууруулах чиглэлээр Улирлын ТТӨвчний вакцинжуулалтад 237, Улаан бурхны эсрэг дархлаажуулалтад 170 эмч, эмнэлгийн ажилчдыг хамруулсан. Мөн урьдчилан сэргийлэх зөвлөмж постеруудыг төвийн цахим групп пэйж хуудсаар дамжуулан нийт ажилчид, үйлчлүүлэгчдэд мэдээллийг түгээж ажиллаа.	
2.10	Аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх, бутлах	-	Аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх, бутлах	ЭМС-ын 2023 оны А/357 тоот тушаалын дагуу unisef-тай	Эмнэлгийн аюултай хог хаягдлыг дотооддоо буталж, халдваргүйжүүлэх	ЭМС-ын 2023 оны А/357 тоот тушаалын дагуу unisef-тай хамтран эмнэлгүүдэд аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх,	100 %

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	төхөөрөмжийг суурилуулна.		төхөөрөмжийг бүрэн ажиллагаанд оруулсан байна.	хамтран эмнэлгүүдэд аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх, бутлах төхөөрөмжийг хуваарилсан.	төхөөрөмжийг бүрэн ажиллагаанд оруулсан байна.	бутлах төхөөрөмжийг хуваарилаасныг эмнэлгийн ажилчдын зогсоолд шинэ өргөтгөл барьж, тоног төхөөрөмжийг байршуулан бэлэн байдлыг хангасан. Мөн давхар бүрд аюултай хог хаягдлын бункер байгуулснаар бункерийн хоолойд хийсэн хог боловсруулах байрны хог хаягдал цуглах хэсэгт богино хугацаанд дамжлагагүй очдог болгосон.	

ЗОРИЛТ 3:ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫГ ХӨГЖҮҮЛЭХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ

3.1	Ажилтнуудын харилцаа хандлага, үйлчилгээний соёл сайжруулах сургалтыг үе шаттай зохион байгуулна.	5.0	Зохион байгуулсан сургалтын тоо, Албан хаагчдын сургалтанд хамрагдсан хувь	2023 онд Нийт ажилтнуудын 80 хувийг сургалтанд хамруулсан байна.	2024 онд Нийт ажилтнуудын 80-с дээш хувийг сургалтанд хамруулсан байна.	Ажилтнуудын харилцаа хандлага, үйлчилгээний соёлыг сайжруулах үүднээс дараах сургалтыг зохион байгуулсан. 1.“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, 2.“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”, 3.“Сувилагч мэргэжилтний ёс зүйн дүрэм 4.“Үйлчилгээний соёл, харилцаа хандлага” 5.“Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандарт” 6."Эмч, эмнэлгийн ажилтны үйлчлүүлэгчтэй харилцах харилцааны ур чадвар"-ийг сайжруулах чиглэлээр нийт 15 удаагийн сургалтыг зохион байгуулж төвийн эмч эмнэлгийн мэргэжилтнийг 100 % хамруулсан.	100%
3.2	Төвийн хэмжээнд удирдах ажилтны чадавхижуулах сургалтыг зохион байгуулна.	-	Сургалтад хамрагдсан удирдах ажилтны тоо	2023 онд ЭМЯ-ний захиалгат удирдах ажилтны мэргэшүүлэх сургалтад 3 ажилтан хамрагдсан.	Төвийн нийт удирдах албан тушаалтныг бүрэн сургалтад хамруулна.	Гэмтэл согог судлалын үндэсний төвийн тасаг, нэгжийн удирдлагуудыг чадавхижуулах “Удирдах ажилтны сургалт”-ыг зохион байгууллаа. Энэхүү сургалтаар удирдлагын манлайлал, менежментийн шинэ хандлага, нөлөөллийн үр дүн, ажлын бүтээмж төдийгүй байгууллагын хүний нөөцийн бодлого, хөдөлмөрийн дотоод журам, албан хэрэг хөтлөлтийн	100 %

						нийтлэг журам, төрийн албаны бичиг хэргийн стандарт, зэрэг зайлшгүй шаардлагатай мэдээлэл, зааварчилгаа, зөвлөмжийг хүргэсэн юм.“Удирдах ажилтны сургалт”-нд тасаг, нэгжийн удирдлага, дунд шатны менежерүүд болох нийт 102 хүн оролцож, дадлага ажлын даалгавар болон бодит баримтанд тулгуурласан мэдээллүүдийг авч, мэдлэг туршлагаа тэлсэн байна.	
3.3	"Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг шинэчлэн батлуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.	100.0	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2020-2023 онд захирлаар батлуулан 2023 онд 20 ажил хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн төслийг боловсруулж байна.	Жилийн эцсийн байдлаар: Төлөвлөгөөнд тусгагдсан 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг 85%-д хүргэнэ.	Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг захирлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 1.Захирлын А/49 тоот тушаалаар нийт ажилтны цалинг 10-30 хувиар нэмэгдүүлсэн. 2.Захирлын 2024 оны А/64 тоот тушаалаар төвийн нийт эмч, ажилтнуудад олгох хоол, унааны зардлыг ажлын нэг өдрийн 10,000 (арван мянга) төгрөг болгон нэмэгдүүлсэн. 3. Захирлын тушаалаар 2024 оны 1, 2, 3-р улирлын үр дүнгийн урамшууллыг 941 ажилтанд 540,050,060 сая төгрөгийг олгосон байна. 4. Ур чадварын нэмэгдэл 420 эмч, эмнэлгийн ажилтанд үндсэн цалингийн 10-25 хувиар тооцож олгож байна	100 %

						5. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлийн нэмэгдлийг 760 эмч, ажилтанд олгож байна. 6. Ээлжид ажиллаж байгаа эмч эмнэлгийн ажилтнуудад өглөө, оройн хоолыг үнэ төлбөргүй олгож байна. 7. Эмч, эмнэлгийн ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор алжаал тайлах төвийг 2020 оноос эхлэн ажиллуулж байна. Алжаал тайлах төвд эмч, эмнэлгийн ажилтнуудыг чийрэгжүүлэх цагийг зөв боловсон өнгөрөөх зорилгоор фитнес, иогоор хичээллэх тоног төхөөрөмжөөр хангаж, тогтмол үйл ажиллагааг явуулж байна. 8. 2024 оны 05-р сарын 31-нд “Алдарт эхийн одонтой” ээжүүдийг алдаршуулах зорилгоор “Алдарт эхийн одон”-той 27 ээжид хүндэтгэл үзүүлэн, дурсгалын бэлэг гардуулах үйл ажиллагааг зохион байгуулав. 9. Ажилчдынхаа амьдрах орчин нөхцөлийн сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор эмч, эмнэлгийн ажилтанд 5 ханатай гэр олгосон.	
--	--	--	--	--	--	---	--

					10. Ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх үүднээс “Өвөржанчивлан” рашаан сувиллын газартай хамтран 20 ажилтныг цалинтай чөлөө олгож, үнэ төлбөргүй эмчилгээ сувилгаанд хамруулсан. 11. Нийт ажилтнуудынхаа нийгмийн баталгааг хангах, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олныг бий болгох, ахуйн осол гэмтлээс хүүхдийг урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд 2020 оноос эхлэн нийслэлийн 94 дүгээр цэцэрлэгтэй хамтран ажиллаж байна. 2024 онд харьяалал харгалзахгүй эмч, ажилтнуудын 46 хүүхдийг харьяалал харгалзахгүйгээр хамруулж, сургуулийн өмнөх боловсрол олгох, сурган хүмүүжүүлэхэд анхаарч ажиллаж байна. Тус цэцэрлэгийн түүхт 40 жилийн ойн баяр тохиож буйтай холбогдуулан хүүхэд багачуудын оюуны хөгжлийг дэмжих зорилгоор ГССҮТ-ийн Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран хүүхдийн “Номын сан”-гийн өрөөг иж бүрэн засварлаж, тохижуулж хүлээлгэн өгсөн. Төвийн хэмжээнд “Хүүхэд багачууддаа хөөрхөн номоо	
--	--	--	--	--	--	--

						хандивлацгаая” аяныг зохион байгуулж, эмнэлгийн нийт ажилтнуудын зүгээс 2-5 насны хүүхдийн хүсэл сонирхол, оюуны хөгжилд нийцсэн олон төрлийн ном, товхимол, гарын авлага, буддаг ном зэргийг тус цэцэрлэгийн “Номын сан”-д хандивласан. 12. Эмч, эмнэлгийн ажилтнуудыг ажлын зайлшгүй шаардлагаар амралтын өдөр болон ажлын бус цагаар ажиллуулсан тохиолдолд илүү цагийн хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу олгож байна. 13. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.3 дахь заалтын дагуу эхний 1-11 сарын байдлаар аав, ээж, ах, эгч, дүү нь өөд болсон 199 ажилтанд нийт 55,750,000 төгрөгийн тэтгэмж олгосон. 14. Эмч, эмнэлгийн ажилтнуудын ар гэрт гачигдал гарсан тохиолдолд цалинтай чөлөө 199 ажилтанд олгосон. 15. Тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан ажилдаа амжилт гарган ажилласан 106 ажилтныг төрийн дээд одон, медаль, салбарын болон бусад байгууллагын шагналаар шагнаж урамшуулсан.	
--	--	--	--	--	--	---	--

						Шагналын дагалдах 7,800,540 төгрөгийн урамшуулал олгосон. 16. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг (10-20 хувь) нийт 199 эмч, эмнэлгийн ажилтнуудад олгож байна.	
3.4	Төвийн эмч,сувилагч, тусгай мэргэжилтнийг хариуцлагын даатгалд хамруулна.	100.0	Даатгалд хамрагдсан ажилтны тоо	Төвийн хэмжээнд алсын дуудлагад явдаг 45 ажилчид гэнэтийн ослын даатгалд хамрагдсан.	Төвийн эмч,сувилагч,тусгай мэргэжилтнийг мэргэжлийн хариуцлагын даатгалд бүрэн хамруулсан байна.	Эмч,эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулах чиглэлээр харьцуулсан судалгааг хийж даатгалын талаарх мэдээлэл сургалтыг эмч, эмнэлгийн ажилчдад 2 удаагийн сургалтаар мэдээлэл өгсөн.	50%
3.5	Уян хатан ажлын цагийн зохицуулалтыг хэрэгжүүлж ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангана.	-	Ажилтнуудын сэтгэл ханамжийн хувь	-	Ажлын цагийн уян хатан зохицуулалтыг хэсэгчлэн нэвтрүүлсэн байна.	ЭМС-ын 2014 оны 13 дугаар тушаалаар батлагдсан судалгааны маягтын дагуу жил бүр нийт ажилтнуудаас судалгааг авдаг. Энэ жилийн судалгаанд төв эмнэлгээс 450 гаруй ажилтан, салбар эмнэлгийн 160 гаруй ажилтан хамрагдсан. Нийт 600 гаруй ажилтнаас судалгааг авахад Ерөнхий сэтгэл ханамж 95 хувьтай, өмнөх оноос 7,9 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан. Өмнөх оны эмч, ажилтнаас авсан сэтгэл ханамжийн судалгааны хүрээнд дараах заалтыг “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусгаж өгсөн. Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 “Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн	100 %

						уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ” гэсэн заалтын дагуу ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх, ажилтны ажил амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх зорилгоор 7.2.1-д зааж өгсөн. Үүнд: Тухайн ажилтны ажлын өдрийн эхлэх болон дуусах цаг нь 60 минутын өмнө, эсхүл хойно байж болно. Ажлын цаг 7:30 цагт эхэлж, 16 цагт дуусахаар тусгаж өгсөн.	
3.6	Байгууллагын үйл ажиллагааг авлигын эрсдлээс ангид байлгах, Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, НАНБХАСЗАСЗУС тухай зэрэг хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажлын төлөвлөгөө гаргана.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 онд 5 зорилтын хүрээнд 20 ажил хийхээр төлөвлөж, 100 хувь бүрэн хэрэгжүүлсэн. ЭМЯамны хуулийн хэлтэс, эрх бүхий албан тушаалтанд хуульд заасан хугацаанд бүрэн тайлагнасан.	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байна.	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын 2024 оны 2 дугаар сарын 3/859, 7 дугаар сарын 2-ны өдрийн 3/2830 дугаартай албан бичгүүдээр ирүүлсэн Эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ГССҮТөвд хэрэгжүүлэх Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, Ерөнхий захирлаар батлуулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах,	100%

					соён гэгээрүүлэх, Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан тушаалтнуудыг сургалтад хамруулах, Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох, Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах, Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх зэрэг 5 зорилтын хүрээнд 15 чиглэлийн ажил төлөвлөсөн ба эхний хагас жилийн хэрэгжилтийг 2024 оны 5-р сарын 31-ны байдлаар Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтэст тайлагнасан. ГССҮТөв нь АТГазрын Олон нийтийн зөвлөлөөс гаргасан видео шторк, зурагт хуудас, сурталчилгааны материалыг эмнэлгийн фб хуудас, электрон болон ханын самбараар олон нийтэд хүргэх, үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, гарсан зөрчлийг арилгах, мэдээллийн ил тод байдлыг хангах, хүний нөөцийн нээлттэй сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу хийх зэрэг ажлуудыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүллээ. ГССҮТөвийн удирдлагын баг, тасаг албадын дарга, ахлах сувилагч нар, захиргааны ажилтнуудад “Онч	
--	--	--	--	--	---	--

						шийдэл” ТББ-ын тэргүүн Ш.Алтангадас, хуульч Б.Цэрэнлхам нараас “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”, “Авлигын эрсдлийн үнэлгээ” сэдвээр сургалт авч, тус байгууллагаар 2025 оны 1-р улиралд “Авлигын эрсдлийн үнэлгээ” хийлгэхээр гэрээ байгуулаад байна. 2024 оны эхний 11 сард холбогдох хууль тогтоомжийн дагуу албан тушаалд нэр дэвшсэн 9 ажилтнаас ХАСУМ, 2023 онд ажиллаж байсан 43 албан тушаалтнаас шинэчилсэн, шинээр албан тушаалд томилогдсон 7 албан тушаалтнаас томилогдсоны дараах ХАСХОМ, 1 албан тушаалтнаас Хөрөнгө орлогын мэдүүлэгт гарсан их хэмжээний өөрчлөлтийн талаарх мэдүүлэг авч, Худалдах худалдан авах үйл ажиллагаанд оролцох 23 үнэлгээний хорооны 121 гишүүнээс Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбарыг гаргуулан АТГазрын цахим санд бүртгэсэн байна.	
ЗОРИЛТ 4:СУРГАЛТ СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ ЭРХЛЭХ, ИННОВАЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, НЭВТРҮҮЛЭХ, БУСАД ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАХ							
4.1	Шинээр нэвтрүүлсэн технологи, өвчний оношилгоо, эмчилгээний төрлөөр	50.0	Гадаад сургалтад хамрагдсан	2023 онд гадаад оронд 52 эмч мэргэжилтнийг сургалтад хамруулсан.	Шинээр нэвтрүүлсэн технологи, өвчний	Тайлант онд нийтдээ дэлхийн 12 улсад -Дээд,доод мөчдийн гэмтлийн үеийн мэс засал	100%

	өндөр хөгжилтэй орны эмнэлгүүдэд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг суралцуулна.		ажилтнуудын тоо		оношилгоо, эмчилгээний төрлөөр өндөр хөгжилтэй оронд 40-өөс доошгүй ажилтныг сургалтад хамруулна.	-Мэдээгүйжүүлэг -Хүүхдийн гэмтлийн үеийн мэс засал -Хүнд хэлбэрийн нурууны мурийлтын мэс засал -Сэргээн засах эмчилгээ -Тархины мэс засал -Дүрс оношилгоо -Дурангийн мэс заслын чиглэлээр нийт 62 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаад сургалтад хамруулсан байна.	
4.2	Гэмтэл согог судлалын 26-р Олон улсын эрдмийн чуулганыг зохион байгуулна.	20.0	Эрдмийн чуулган зохион байгуулагдсан байна.	Гэмтэл согог судлалын Олон улсын 25-р эрдмийн чуулганыг 2023 оны 10 сарын 05,06-ны өдрүүдэд ", Орхон аймгийн БОЭТ хамтран амжилттай зохион байгууллаа. Чуулганд гадаадын зочин профессорын 4 илтгэл, дотоодын эмч, судлаачдын 19 илтгэл оролцсон. Судлаачдын 51 илтгэлээс бүрдсэн хурлын илтгэлийн хураангуй хэвлэгдэн гарсан үзүүлэлттэй байна.	Гэмтэл согог судлалын 26-р Олон улсын эрдмийн чуулганыг зохион байгуулж 50-с доошгүй илтгэлийг сэтгүүлд хэвлүүлсэн байна.	Монголын гэмтэл согогийн эмч мэргэжилтнүүдийн холбоо, АШУҮИС-ийн АУС-ийн Гэмтэл согог судлалын тэнхим, Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс хамтран гэмтэл согог судлалын XXVI эрдмийн чуулганыг “Эрүүл ирээдүйг хамтдаа бүтээе” уриа дор энэ сарын 06-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Энэ удаагийн чуулганаар БНТУ, ХБНГУ, Япон зэрэг орны эрдэмтэн, профессор, судлаач болон нийслэл, орон нутгийн 140 гаруй гэмтэл согог судлалын эмч, мэргэжилтэн, судлаачид илтгэлээ хэлэлцүүллээ. Тухайлбал гадаадын зочин профессорын 4 илтгэл, дотоодын эмч, судлаачдын 21 илтгэлийг хэлэлцүүлсэн бөгөөд нийт 54 илтгэлээс бүрдсэн хурлын илтгэлийн хураангуй хэвлэгдэн гарсан байна.	100%

4.3	Төрөлжсөн нарийн мэргэшлийн эмч нарын 3-6 сарын мэргэшүүлэх сургалт зохион байгуулна.	3.0 сая	Элсэгч, төгсөгчийн тоо	Өвдөгний үений дурангийн мэс засал” мэргэжил дээшлүүлэх, “өвдөг, түнхний үе солих, өвдөг, түнхний үе бүтээх мэс засал” мэргэжил дээшлүүлэх 2 чиглэлээр 10 суралцагч сургах боломжтой.	Сургалтыг дүрэм журмын дагуу элсэлт, төгсөлт, сургалт зохион байгуулна.	Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах гэрээг ЭМХТөвтэй байгуулж дараах 2 чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн батлуулсан. Энэ хүрээнд “ӨВДӨГНИЙ ҮЕНИЙ ДУРАНГИЙН МЭС ЗАСАЛ” чиглэлээр 2 эмч, “ӨВДӨГ, ТҮНХНИЙ ҮЕ СОЛИХ, ӨВДӨГ, ТҮНХНИЙ ҮЕ БҮТЭЭХ МЭС ЗАСАЛ” чиглэлээр 1 эмч төгссөн байна. 2024 оны намрын элсэлтээр дээрх 2 чиглэлээр 3 эмч элсэн суралцаж байна.	100%
4.4	Эмнэлэгт суурилсан төгсөлтийн дараах сургалтыг чанаржуулж, зохиомол сургалтын өрөөг байгуулна.		Тохижуулах өрөөний тоо	Төв эмнэлэг дээр 2021 онд зохиомол орчны бүрдүүлсэн сургалтын өрөөг тохижуулж ашиглалтад оруулсан.	Салбар эмнэлэг дээр сургалтын өрөөг тохижуулан ашиглалтад оруулсан байна.	Эмнэлэгт суурилсан төгсөлтийн дараах сургалтыг чанаржуулах үүднээс ГССҮТөвийн Салбар эмнэлгийн амбулаторийн 3 давхарт 46м ² эмнэлзүйн ур чадварын сургалтын өрөөг шинээр тохижуулан ур чадварын сургалт орж эхэллээ. Сургалтын өрөө нь: -Сургалтад хэрэглэгдэх сувилгааны иж бүрдэл -Дадлага сургуулилтад шаардлагатай хэрэглэлүүд / муляж, багаж хэрэгслүүд гм/ -Тоног төхөөрөмж зэрэг шаардлагатай хэрэгслээр хангаж сургалтын хиймэл орчин бүрдүүллээ. 2024 онд шинээр ажилд орсон сувилагч нарт онол болон дадлага хосолсон эмнэлзүйн сургалтууд	100%

						Сувилагч бусад мэргэжилтнүүдэд эмнэлзүйн бүлгийн сургалтуудыг тус тус зохион байгуулж байна.	
ЗОРИЛТ 5: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ, САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ							
5.1	Байгууллагын санхүүгийн удирдлагыг үр ашигтай хэрэгжүүлж өр авлагагүй ажиллана.	-	Өр, авлагын хэмжээ	ЭМДЕГ-тай 2023 оны 09 сарын 30-ны өдрөөр хийсэн тооцоогоор 25,3 тэрбум төгрөгийн ЭМД-ын авлагатай гарсан. Үүний 14,8 тэрбум нь оны эхний үлдэгдэл байна. 11 сарын байдлаар бэлтгэн нийлүүлэгчид төлөх өр 7,2 тэрбум байна.	Өр авлагагүй ажиллана.	Төсвийн гүйцэтгэл 66,4 тэрбум төгрөгийн төсөвтэй, 61,1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь нийт зардлын 40,1%-ийг цалингийн зардал эзэлж байна. Засгийн газрын 2024 оны 03 сарын 28-ны 128 дугаар тогтоолын дагуу нийт ажиллагсдын цалин 5-25 хувь нэмэгдсэн. ЭМД-ын санхүүжилт дутуу хийгдэж байгаагаас төсөвт хэмжээнд зардлыг зарцуулж чадахгүй, бэлтгэн нийлүүлэгчид өртэй гарч байна.	100 %
5.2	Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй тусламж үйлчилгээг даатгалд хамруулахад шаардлагатай саналыг хүргүүлнэ.	-	Тусламж үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан оношийн хамааралт ай бүлгийн тоо.	2023 онд нийт 172 ОХБүлгээр тусламж үйлчилгээ үзүүлж байна. Өмнөх онтой харьцуулахад 16 бүлгээр нэмэгдсэн. Мөр, шагайн хиймэл үе солих мэс засал, суулгасан хиймэл үений суулгацыг дахин солих гэх мэт 40 мэс заслын өртөг зардлыг тооцож ЭМДҮЗ-ийн 01-р тогтоолын оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад нэмж оруулах саналыг ЭМДЕГ-т хүргүүлсэн боловч	Тусламж үйлчилгээний төрөл, хүртээмж, оношийн хамааралтай бүлгийн тоо нэмэгдсэн байна.	Мөр, тохой, шагайн хиймэл үе солих мэс засал, суулгасан хиймэл үений суулгацыг дахин солих гэх мэт 41 мэс заслын өртөг зардлыг тооцож ЭМДҮЗ-ийн 08-р тогтоолын оношны хамааралтай бүлгийн жагсаалтад нэмж оруулах саналыг 2024 оны 2 сарын 15-нд, 2024 оны 7 сарын 16-нд ОХБүлэг нэмэх болон үнийн санал, 2024 оны 11 сарын 01-нд дахин ЭМДЕГ-т хүргүүлсэн байна. Мөн ЭМДЕГ-азарт 2022 оноос эхлэн Телемедицин болон түргэн тусламжаар нэмэлт гэрээ байгуулах хүсэлт нийт 6 удаа явуулсны дараа 2024 оны 08	100%

				хараахан шийдээгүй байна.		дугаар сарын 06-ний өдөр гэрээ байгуулсан байна.	
5.3	Эрүүл мэндийн салбарт 2023-2026 онд хэрэгжүүлэх төр,хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	-	Гэрээлэн гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээн ий тоо	Төвийн хэмжээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэлд заасан үйл ажиллагааны чиглэлээр байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	Төвийн хэмжээнд хувийн хэвшил төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломж-той ажил үйлчилгээний үр ашиг зардлыг тооцож эдийн засгийн үр өгөөж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг гэрээлэн гүйцэтгүүлсэн байна.	Төвийн хэмжээнд хувийн хэвшил төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой ажил үйлчилгээг дараах чиглэлээр гэрээлэн гүйцэтгүүлсэн байна. Эрүүл мэндийн салбарын удирдлага зохион байгуулалтын чиглэлээр -5 Дэмжих үйлчилгээний чиглэлээр-37	100%
ЗОРИЛТ 6: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭРГЭШСЭН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ, ОСОЛ ГЭМТЛИЙН ҮЕИЙН ТАНДАЛТ СУДАЛГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ							
6.1	“Монгол улсын осол гэмтлийн тандалт” 2019-2023 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын байдалд тархвар зүйн судалгаа хийж, 300 ширхэг сэтгүүлийг хэвлүүлэн холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргэж, цахим хэлбэрээр олон нийтэд түгээнэ.	15.0	Хэвлэгдсэн сэтгүүлийн тоо, Цахим хандалтын тоо	“Монгол улсын осол гэмтлийн тандалт” 2017-2021 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын тархварзүйн судалгааг хийж, 350 ширхэг сэтгүүлийг хэвлүүлэн холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргэсэн.	Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нотолгоонд суурилсан эргэн мэдээллээр хангах судалгааны тайлан сэтгүүл 300 ширхэг хэвлэгдэж, хэрэглэгчдэд	Осол гэмтлээс сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх үйл ажиллагааг нотолгоот мэдээллээр хангах зорилго бүхий “2019-2023 онд Монгол улсад бүртгэгдсэн осол гэмтлийн шинэ тохиолдол тархвар зүйн судалгаа” хийж, тайлан сэтгүүл монгол хэл дээр 300, англи хэл дээр 100 ширхэг хэвлүүлж, үр дүнг танилцуулах өдөрлөг зохион байгуулан холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргэсэн.	100%

					цахим хэлбэрээр ашиглах боломжийг бүрдүүлнэ.		
6.2	“Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас АМ-33” маягтыг цахимд оруулна.	6.0	Цахимд бүртгэгдсэн бүртгэлийн тоо	Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас АМ-33 маягтад жилд 168477, өдөрт дунджаар 462 үйлчлүүлэгчийн мэдээлэл цаасан хэлбэрээр бүртгэгдэж байна.	“Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас АМ-33” маягт цахимд оруулж, 2024 онд яаралтай тусламж авсан шинэ тохиолдлыг бүртгэсэн байна.	Төвийн хэмжээнд яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн мэдээллийг цахим программд бүртгэж, маягтын паспортын хэсгийг хөтлөн эмч рүү илгээж байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар хугацаанд 162069 үйлчлүүлэгчийн “ОГТБХ” маягт хөтөлж, Ehealth программд бүртгэж, үзлэгийн эмчид илгээсэн.	100%

6.3	“Осол, гэмтлээс сэргийлэх 14 хоногийн аян”-ыг зохион байгуулна.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	МУ-ын ЗГ-ын 224-р тогтоолын дагуу жил бүрийн 01 сарын 15-30-ны өдрийн хооронд тус аяныг зохион байгуулж хэвшсэн.	Аяны хүрээнд төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	ГССҮТ-ийн Ерөнхий захирлын 2024 оны 01 сарын 11-ний өдрийн А/02 тоот тушаалын дагуу Осол гэмтлээс сэргийлэх 14 хоногийн аян “ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ - ТАНЫ ХАРИУЦЛАГААС” сэдэв дор зохион байгуулж ЭМЯ, НЭМҮТ болон ГССҮТ байгууллагын үндсэн цахим хуудсаар дамжуулан хүүхдийг зам тээврийн осол, гэмтэл, хараа хяналт сул байдлаас болон бусад ахуйн хүрээний осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, яаралтай тохиолдолд авах хариу арга хэмжээ, хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх зэрэг зөвлөмж, мэдээлэл бүхий постер, зурагт хуудсуудыг цахим орчинд байршуулан “ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ - ТАНЫ ХАРИУЦЛАГААС” аяныг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан.	100 %
6.4	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн салбарын талаарх мэдлэг, хандлага, ойлголтыг нь нэмэгдүүлнэ.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Салбарын хэмжээнд зохион байгуулж буй томоохон үйл ажиллагаа, дэвшилтэт технологи, тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, ололт амжилтыг сурталчилсан 12 удаагийн арга хэмжээг зохион байгуулж мэдээ	Томоохон үйл ажиллагаа, дэвшилтэт технологи, тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, ололт амжилтыг 20-с доошгүй	Байгууллагын вэб сайт, пэйж хуудасны хандалтын тоог нэмэгдүүлэх зорилгын хүрээнд цаг үеийн мэдээ, PR мэдээлэл, гэмтэл согогийн нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөө, албан ёсны тоо баримт, эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн шинэ аргачлал, дэвшилтэт технологи	100 %

				мэдээллийг эмнэлгийн цахим хуудас болон нийгмийн цахим сүлжээнд байршуулж ажилласан.	удаа арга хэмжээг зохион байгуулсан байна.	болон хамтын ажиллагаа ололт амжилтын талаарх 46 үйл ажиллагааны мэдээ мэдээллийг эмнэлгийн цахим хуудас болон нийгмийн цахим сүлжээнд байршуулсан.	
6.5	Эрүүл чийрэг эр хүн арга хэмжээний хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээ, оролцогчдын тоо	2021 онд байгууллагын эрэгтэй ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулж байсан.	Байгууллага, иргэд олон нийтийг ажлын байран дахь хөдөлгөөний хомсдол болон илүүдэл жингээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулагдсан байна.	Эрүүл амьдралын хэв маягийг бий болгох, байгууллагын эрэгтэй эмч, эмнэлгийн ажилтнууд болон иргэд олон нийтэд чиглэсэн эрэгтэйчүүдийн эрсдэлт зан үйлийг бууруулах талаар 7 төрлийн мэдээлэл, зөвлөмж, постерийг ГССҮТөвийн пэйж хуудсаар тогтмол олон нийтэд мэдээлэл бэлтгэж хүргэсэн. Нийт 1200 гаруй хандалт, лайк, 135 гаруй шэйр авсан.2024 онд дараах 5 арга хэмжээг зохион байгуулсан. “Эрүүл жиндээ –2” аян зохион байгуулж тус аяны хүрээнд: -“Чингэлтэй хайрхан уул”-д алхах үйл ажиллагаанд 59 эмч эмнэлгийн ажилчид оролцлоо. -ГССҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дундах биеийн жингийн индексийн үзүүлэлтийн судалгаанд үндэслэн илүүдэл жинтэй 68 оролцогч 17 багийн дунд багийн бооцоот уралдаан зохион байгуулсан. -"Улаанбаатар Марафон 2024"- олон улсын гүйлтийн тэмцээнд 23 эмч,эмнэлгийн мэргэжилтэн амжилттай оролцлоо.	100%

						- Байгууллагын хэмжээнд эрүүл мэндийг дэмжин спортын гурван төрөлт тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. - Төвийн эмч, эмнэлгийн ажилтнуудын урьдчилан сэргийлэх, илрүүлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах захирлын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/114 тоот тушаалын дагуу 2024 оны 09 сарын 02-ны өдрөөс 10 сарын 04-ны өдрийн хооронд зохион байгууллаа.	
6.6	Осол гэмтлийн үеийн анхны тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх осол ихээр гардаг хар цэгүүдэд мэргэжлийн багийг ажиллуулна.	-	Ажилласан багийн тоо	Орон нутагт осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах уулзалт, сургалтыг хийсэн.	Ослын цэгээс эмнэлэг хүртэлх анхны тусламжийг цаг алдалгүй үзүүлэхэд мэргэжлийн багийг ажиллуулж тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.	Орон нутгийн эмч, мэргэжилтний мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг, Ховд аймгийн БОЭТ-д толгой, гар сарвуу, доод мөчдийн мэс заслын чиглэлээр 6 эмчийн бүрэлдэхүүнтэй баг үзлэг оношилгоо болон мэс заслын эмчилгээ хийж ажиллаа.	90%
6.7	Сонсголгүй иргэдийг дэмжих чиглэлээр “ дохионы хэл ”-ний сургалт зохион байгуулна.	2.0	Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо	2023 онд дохионы хэлний сургалт зохион байгуулагдаагүй	Сонсголгүй иргэдийг дэмжих чиглэлээр “ дохионы хэл ”-ний сургалт зохион байгуулаж төвийн хэмжээнд 50-аас доошгүй ажилтныг	“Шидэт гар” дохионы хэлний сургалтын төвтэй хамтран сувилагч, тусгай мэргэжилтэн, цахим бүртгэгч, хөтөч нарт зориулсан дохионы хэлний анхан шатны сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтыг дохионы хэлний орчуулагч багш, докторант Б.Саранчимэг удирдан явуулж,	100%

					хамруулж, 2 сургагч багшийг бэлтгэж анхан шатны мэдлэг олгож тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт иргэд үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд нэн чухал харилцааны суурь мэдлэг, зайлшгүй анхаарах зааварчилгаа, мэдээлэл, зөвлөмжийг хүргэсэн байна. Дохионы хэлний анхан шатны 2 өдрийн сургалтад сувилагч, тусгай мэргэжилтэн, цахим бүртгэгч, хөтөч зэрэг нийт 56 хүн хамрагдсан мэргэшлийн сертификат авсан.	
--	--	--	--	--	---	---	--

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:

Эрүүл мэндийн сайд
/албан тушаал/

Тэмдэг

.....
/гарын үсэг/

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

/ Т. МӨНХСАЙХАН/

.....
/огноо/

ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАМЛАГНАСАН:

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирал



/албан тушаал/

СУДЛ. АЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ
ТБАГУУГ

Тэмдэг

ТӨВ ХОТ
7219


.....
/гарын үсэг/

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

/Э.ГАЛБАДРАХ/

.....
/огноо/

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

ХАВСРАЛТ

Арга
хэмжээ
1.1

Спортын гэмтлийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд 4 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. 2024 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 100 %-ийн үзүүлэлттэй байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралт

Тайлагнасан
СЭЭХДэд захирагч
(аргын үсэг)

Тайлагнасан
Спортын гэмтлийн төв
(аргын үсэг)

(О.Хилигсүрэн)
Огноо: (2024.11.27)

(О.Баттүх)
Огноо: (2024.11.27)

СПОРТЫН ГЭМТЛИЙН ТӨВ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Хийг ажил	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (Хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА						
Хувь хүний ажлаар хангагдсан						
1.1	Эмнэлэгээр мэргэжлээр гүйцэтгэх ажил үүргийг гүйцэтгэх чадвартай ажилчдыг хангах	Хувь хүний ажил	Ажил хэргийн түвшинг тогтоож сурталтад хангуулах	Сертификат дугаар ✓ VA-24314 ✗ VA-24452	1 болон 3 дугаар үйлчилгээний төвд нэг О.Ангаланжүүгийн С.Занжаргал нэр анхны хэлний түвшинг хангуулах сурталтад хангагдсан	100%

Арга
хэмжээ
1.2

Нөхөн сэргээх эмчилгээг цогцоор үзүүлэх нэгжийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд 6 зорилтын хүрээнд 21 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. 2024 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 100 %-ийн үзүүлэлттэй байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралт

ТАЙЛАН ХЯНАСАН:
ЭМНЭЛЭГ ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ
(албан тушаал)

ТАЙЛАГНАСАН:
НӨХӨН СЭРГЭЭХ МЭС ЗАСЛЫН ТАСГИЙН ЭРХЛЭГЧ
(албан тушаал)

(О.Хилигсүрэн)
(Огноо) 2024/11/29

(О.Цэрэндорж)
(Огноо) 2024/11/29

САЛБАР ЭМНЭЛЭГ НӨХӨН СЭРГЭЭХ МЭС ЗАСЛЫН ТАСГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт/хүрээгүй бол тайлбар	Гүйцэтгэлийн хувь
Зорилт 1. ГССҮТ- салбар эмнэлэг НСМЭТасгийн мээ заслыг чанаржуулах							
1	Гэмтлийн дараах арьс зөөлөн эдийн дутмагшил бүхий шархыг бичил судастай чөлөөт эдээр нөхөх мээ заслыг НСМЭТ-т нутагшуулах	Байгууллагын төсөв	Элсн улсын ирдата сайтны судалгаа	2023 оны II улирлаас хийгдэж эхэлсэн	2024 онд гэмтлийн дараах арьс зөөлөн эдийн дутмагшил бүхий шархыг өөрийн чөлөөт эдээр нөхөх мээ заслыг НСМЭТ-т нутагшуулах	2024 оны зорилтын дагуу НСМЭТ-т Том хэмжээний арьс зөөлөн эдийн дутмагшил бүхий шархыг бичил судастай чөлөөт эдээр нөхөх мээ засал нийт 5 хүнд хийснээс 2г нь үр дүнтэй амжилттай болж нутагшуулж байна.	100%

MNS 7101:2023 Эрүүл мэндийн байгууллагын чанарын менежментийн тогтолцоо, шаардлага стандартыг төв болон салбар эмнэлгийн хэмжээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд ЭМТҮЧАБА албаны 6 мэргэжилтэн тус стандартын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. Тус стандартыг хэрэгжүүлэх хүрээнд 2023.06.14 “Аму консалтинг” ХХК-тай хамран ажиллах гэрээ байгуулаж тус стандартын танилцуулга хичээлийг төвийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.



Арга
хэмжээ
1.4

Захирлын 2024.01.22 А/17 тоот тушаалаар төв болон салбар эмнэлгийн хэмжээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2015 стандартыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сургалтын тайлан: Хавсралт 3

Арга
хэмжээ
1.6



МӨР ЭРГҮҮЛЭГЧ ШӨРМӨСНИЙ СЭРГЭЭХ БОЛОМЖГҮЙ УРАГДАЛД ГУЯНЫ ШӨРМӨСӨӨР НӨХӨН СЭРГЭЭХ ДУРАНГИЙН МЭС ЗАСАЛ ХИЙЛЭЭ. Спортын гэмтлийн тасгийн эмч, мэргэжилтнүүд Монголд анх удаа мөр эргүүлэгч шөрмөсний сэргээх боломжгүй урагдалд үний дурангийн мэс заслын аргаар гуяны шөрмөс шилжүүлэн нөхөн сэргээх эмчилгээг амжилттай хийлээ.

Арга
хэмжээ
1.7



ЯСНЫ ХОРТ ХАВДАРТАЙ ХЭСГИЙГ БҮРЭН АВЧ, ХИЙМЭЛ ЯС ҮЕ СУУЛГАХ МЭС ЗАСЛЫГ АМЖИЛТТАЙ ХИЙЛЭЭ. Ясны эмгэгийн мэс заслын тасгийн хамт олон БНСУ-ын эмч нартай хамтран ясны хортой хавдрын тохиолдолд дунд чөмөгний булууны хавдрыг авч, хиймэл үе (мега-протез) суулгах мэс заслыг амжилттай хийлээ.



ШАГАЙН ДУРАНГИЙН МЭС ЗАСЛЫН ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЛЭЭ. Спортын гэмтлийн мэс заслын тасгийн хамт олон Монгол Улсад анх удаа шагайн гадна хажуугийн холбоосыг дурангийн мэс заслын аргаар сэргээж, эмчилгээний шинэ технологи нэвтрүүлээ.



ТОХОЙН ҮЕ, АТГААЛ ЯСНЫ ДУТМАГШЛЫГ НИЙЛМЭЛ ХИЙМЭЛ ҮЕЭР (МЕГАПРОТЕЗ) СОЛИХ МЭС ЗАСЛЫГ ШИНЭЭР НЭВТРҮҮЛЛЭЭ. Гар сарвууны мэс заслын тасгийн эмч нар ослын дараах атгаалын чөмөгт ясны доод хэсэг бяцарч, үйрмэг мэт болон хугарч, эргэн сэргэшгүй болж дутмагшил үүссэн (10см орчим) ясыг орлуулах, үеийг орлуулсан, нийлмэл тохойн хиймэл үе бүхий имплантыг суурилуулан гарын хөдөлгөөнийг бүрэн сэргээж, амьдарлын чанарыг сайжруулах мэс засал эмчилгээ юм.



ҮЕНИЙ ГАДАРГУУ МӨГӨӨРСИЙГ ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ МЭС ЗАСЛЫН ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЛЭЭ. Насанд хүрэгсдийн мэс заслын тасгийн эмч нар дунд чөмөгний булуу шаант ясны тавцанд нэг моментоор үений гадаргуу мөгөөрс шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээг анх удаа хийлээ.



Зураг 1. Өсдөгний үеийн дунд чөлөөтэй гадна бутлуурны мөглөрсөн эрхэн гэмтэл

Зураг 2. Өсдөгний үеийн мөглөрсөн эрхэн гэмтэлтэй хэсгийг бэлтгэсэн байдал



Арга
хэмжээ
1.8

ӨНДӨР ДАРАЛТАТ ХҮЧИЛТӨРӨГЧИЙН ЭМЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛЛЭЭ.



Арга
хэмжээ
1.11

Ясны хавдрын оношилгоо эмчилгээг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт 27 арга хэмжээний хүрээнд төлөвлөж хэрэгжилт 100%-ийн үзүүлэлттэй байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралт.

Тайланг хянасан:
ЭМНЭЛЗҮЙ ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ
(албан тушаал)

Тайлагнасан:
ТАСГИЙН ЭРХЛЭГЧ

2024.11.18

2024.11.18

ЯСНЫ ЭМГЭГИЙН МЭС ЗАСЛЫН ТАСГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙДАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. ЯСНЫ ЭМГЭГТЭЙ ЭМЧЛҮҮЛЭГЧИЙН ТУСЛАМЖ ҮЙДЧЛГЭЭГ САЙЖРУУЛАХ							
Зорилт 1. Ясны бүтэц нягтралын эмгэгийн оношилгоо, эмчилгээний удирдамж боловсруулах							
1.1	БНСУ-ын ясны хавдрын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эмнэлэгтэй хамтын ажиллагаа үүсгэх	Доголд нөөц боломж	Үүсгэсэн байгууллагын тоо	1	1	БНСУ-ын Korea cancer center- Orthopaedic department тасгийн эрхлэгч Чо Ван Хонг	100%


Арга
хэмжээ
1.13

2024.08.30-2024.08.31 ний өдрүүдэд Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага “Жайка”-н болон ЭМХТ-тэй хамтран эмнэл зүйн сургагч багшаар 24 сувилахуйн мэргэжилтэн бэлтгэж төгсгөлөө.



Арга
хэмжээ
2.1

ГССҮТ-д 2024 онд нийт **529** эрсдэл бүртгэгдсэнээс Ноцтой буюу улаан эрсдэл 101 /19.1%/, өндөр буюу улбар шар эрсдэл 274 /51.8%/, дунд буюу шар эрсдэл 133 /25.1%/, бага буюу ногоон эрсдэл 21 /4.0%/ тус тус бүртгэгдсэн байна.



ГССҮТ-н 2024 онд нийт 529 эрсдэл бүртгэгдсэнээс Эмнэлзүйн тусламж үйлчилгээтэй холбоотой эрсдэл 114 буюу нийт эрсдэлийн 21.6%-г эзэлсэн байна.

2024 онд эмнэлзүйн болон эмнэлзүйн бус нийт 529 эрсдэл бүртгэгдсэнээс өндөр буюу улаан эрсдэл 101 буюу нийт эрсдэлийн 19.1%-г эзэлсэн байна. Үүнээс өндөр буюу улаан эрсдэлийн биелэлтийн хувь 15.8% буюу нийт эрсдэлийн биелэлтийн хувь 39.5% байна

№	Эрсдэлийн ангилал /Төрлөөр нь/	Ногоо	Дунд	Улаан шар	Ногоон	Бүгд
1	Эмнэлзүйн тусламж үйлчилгээтэй холбоотой	32	54	25	3	114 21.6%
2	Эм. биобаддмалтай холбоотой эрсдэл	25	28	10	0	63 11.9%
3	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжтэй холбоотой эрсдэл	11	30	23	1	65 12.3%
4	Халдвар хамгаалал	10	40	14	1	65 12.3%
5	Хүний нэвчийн хангамж, хуртээмж, мэргэшсэн байдал	3	23	15	2	43 8.1%
6	Ажлын байрны чадамж, мэргэшсэн байдал	2	6	2	0	10 1.9%
7	Дотоод орчны эрсдэл	6	38	21	6	71 13.4%
8	Гадарг орчны эрсдэл	2	5	1	0	8 1.5%
9	Мэдээллийн систем, компьютер хэрэгсэлтэй холбоотой эрсдэл	4	16	2	1	23 4.3%
10	Ажлын байрны эрсдэл	2	7	2	0	11 2.1%
11	Ёс зүйтэй холбоотой гарч болох эрсдэлүүд	0	2	2	0	4 0.8%
12	Ажлын хангамж/нийгмийн асуудал	0	7	5	4	16 3.0%
13	Баримт бичиг	0	2	0	0	2 0.4%
14	Үйлчилүүлэгч	2	11	0	3	16 3.0%
15	Бусад	2	5	11	0	18 3.4%
Нийт		101	274	133	21	529 100%
Хувь		19%	52%	25%	4%	100%

Үнэлгээ	2023 он				Биелэлт 2023		2024 он				Биелэлт 2024	
	Хагас жил		Бүтэн жил				Хагас жил		Бүтэн жил			
У	96	21.4%	83	25.7%	10	8%	101	19.1%	88	21.3%	33	15.8%
У.Ш	248	55.2%	145	44.9%	103	84%	274	51.8%	155	48.4%	119	56.9%
Ш	95	21.2%	90	27.9%	5	4%	133	25.1%	90	28.1%	43	20.6%
Н	10	2.2%	5	1.5%	5	4%	21	4.0%	7	2.2%	14	6.7%
Нийт	449	100.0%	323	100%	123	100%	529	100.0%	320	100%	209	100%
						27%						39%

ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮД ГАМШГИЙН ҮЕИЙН ДУУТ ДОХИОГООР АЖИЛЛАХ ДАДЛАГА СУРГУУЛИЛТ ХИЙЛЭЭ. Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвөөс улс орон даяар зарлан мэдээллийн дохиог гурван удаа дамжуулсан бөгөөд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, хэвтэн эмчлүүлэгчид өөрт ойр байгаа аюулгүйн цугларах талбайд гарч, дадлага сургуулилтад оролцсон юм.

Арга
хэмжээ
2.3



Улсын онцгой комиссын 2024 оны 01 албан даалгаварийн хүрээнд:



ГЭМТЭЙ СОГОГ СЭДЛЭМН ҮНДСЭЙН ТӨВНИЙ ЦАР УСНЫ ТЕР, ТӨРӨН ХӨНДӨӨС ҮНДЭВНЭН СЭРГЭЭЖ АЖЛАХ ТӨЛӨӨЛӨӨ ГЭМТЭЙ СОГОГ СЭДЛЭМН 2024.01.01 - 2024.05.31

Д/с	Төлөөлөгч	Хариуцаж байгаа байр	Хүлээн зориулж байгаа үйлдлийн төлөв
1	Бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв	Гэмтэй, эрүүл үед байгууллагад хэрэглэж байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа	Бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа
2	Бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв	Гэмтэй, эрүүл үед байгууллагад хэрэглэж байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа	Бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа
3	Бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв	Бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа	Бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа
4	Бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв	Бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа	Бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа, бэлтгэлтэй өргөмжлөх үйлдлийн төлөв байгаа




ГССҮТөв нь 2024 онд Нурууны мэс засал болон Хавсарсан гэмтлийн мэс заслын тасгийг үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд тохируулан иж бүрэн засвар хийж, ашиглалтад орууллаа. Тухайлбал төвийн тус 2 тасгийн өрөө бүрт гүйдэг хаалга, кондейшн, интернет сүлжээ, 180 градус эргэдэг орны гэрэл, цахилгаан залгуур, дуут дохиолол бүхий утаа мэдрэгчийг суурилуулж, дуу чимээнээс тусгаарлах эмнэлгийн зориулалттай эко хавтангаар ханыг засварлан тохижуулжээ. Мөн цэвэр болон бохир усны шугамыг шинэчилж, үйлчилгээний ажилтнуудын ажлыг хөнгөвчлөх зориулалтаар цэвэрлэгээний ус авах, бохир ус зайлуулах тусгай буланг байгуулсан байна. Засвар үйлчилгээтэй холбогдуулан тухайн тасгийн бүх орыг шинээр сольж, өрөө тус бүрийг ариун цэврийн өрөөтэй болгосон бөгөөд хэвтрийн болон асаргаа сувилгаа шаардлагатай үйлчлүүлэгчдэд зориулсан асаргааны өрөөг нэмж тоноглон засварлажээ. Түүнчлэн нийтийн эзэмшлийн талбай буюу коридорт эрчим хүчний хэмнэлт бүхий гурван шатлалт гэрлийн унтраалга, галын дохиоллын систем, аваарын гарц, төмөр дүүжин тааз хийснээр эмнэлгийн тусламж үйлчилгээг стандарт шаардлагад нийцсэн тохилгог орчинд үзүүлэх бүрэн боломжтой болж байгаа юм.

Арга
хэмжээ
2.4



Төвийн цахилгааны гадна ТП тоноглол шинэчлэх,нөөц үүсгүүрийн бэлэн байдал хангагдаж автомат сэргэн залгалт хийгддэг болсон.

Арга
хэмжээ
2.5



ЭМС-ын 2023 оны А/357 тоот тушаалын дагуу unisef-тай хамтран эмнэлгүүдэд аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэх, бутлах төхөөрөмжийг хуваариласаныг эмнэлгийн ажилчдын зогсоолд шинэ өргөтгөл барьж, тоног төхөөрөмжийг байршуулан бэлэн байдлыг хангасан.

Арга
хэмжээ
2.10



Мөн давхар бүрт аюултай хог хаягдалын бункер байгуулснаар бункерийн хоолойд хийсэн хог боловсруулах байрны хог хаягдал цуглах хэсэгт богино хугацаанд дамжлагагүй очидог болгосон.



Ажилтнуудын харилцаа хандлага, үйлчилгээний соёл сайжруулах 15 удаагийн сургалтыг зохион байгуулж төвийн эмч эмнэлгийн мэргэжилтнийг 100 % хамруулсан.

Арга
хэмжээ
3.1





Гэмтэл согог судлалын үндэсний төвийн тасаг, нэгжийн удирдлагуудыг чадавхижуулах “Удирдах ажилтны сургалт”-ыг зохион байгууллаа.



ГССҮТ УДИРДАХ АЖИЛТНЫ СУРГАЛТЫН ХОТОВСОР

Хөдөө 2024 оны 7 сарын 20-ний өдөр
Оролцогчдын тоо: 100
Цай: 0.00-19.00

Цай	Үйл ажиллагаа	Нэр аймаг тусгай
09.00-09.30	Хуралдагчийн бүртгэл	
09.30-10.00	Нээлт	Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Засварын 07-ны захирал, Хүний ажил Хүний ажил, Хүний ажил, Хүний ажил Хүний ажил, Хүний ажил, Хүний ажил
10.00-12.30	"Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Боловсруулалт, тайлагнаал"	УИХ Бага Тамар
12.30-12.30	Далдлага амал	Иргэдийн гурдмалын төлөөлөл Боловсруулалт, тайлагнаал
12.30-13.30	Бүрмэл хэл	
13.30-14.30	"Удирдах ажилтны мэтэйдэл"	УИХ-ийн Хүний ажил, Хүний ажил, Хүний ажил М.Балсан
14.30-16.00	"Шийдвэрийн суурь, үйл үндэслэлтэй гаргахад ажиллах ажуулал"	УИХ-ийн Хүний ажил, Хүний ажил, Хүний ажил С.Балсан
16.00-17.30	Бүрмэл хэл, амал Бүрмэл хэл, амал, Бүрмэл хэл, амал Бүрмэл хэл, амал, Бүрмэл хэл, амал	УИХ-ийн Хүний ажил, Хүний ажил, Хүний ажил Балсан С.Балсан
17.30-18.00	Хуралдагчийн гарал байгуулал	
18.00-19.00	Оройн амал	
19.00-19.30	Хяналт	



Арга
хэмжээ
3.2

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг захирлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



Арга
хэмжээ
3.3



Монголын гэмтэл согогийн эмч мэргэжилтнүүдийн холбоо, АШУУИС-ийн АУС-ийн Гэмтэл согог судлалын тэнхим, Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс хамтран гэмтэл согог судлалын XXVI эрдмийн чуулганыг “Эрүүл ирээдүйг хамтдаа бүтээе” уриан дор энэ сарын 06-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Энэ удаагийн чуулганаар БНТУ, ХБНГУ, Япон зэрэг орны эрдэмтэн, профессор, судлаач болон нийслэл, орон нутгийн 140 гаруй гэмтэл согог судлалын эмч, мэргэжилтэн, судлаачид илтгэлээ хэлэлцүүлээ. Тухайлбал гадаадын зочин профессорын 4 илтгэл, дотоодын эмч, судлаачдын 21 илтгэлийг хэлэлцүүлсэн бөгөөд нийт 54 илтгэлээс бүрдсэн хурлын илтгэлийн хураангуй хэвлэгдэн гарсан байна. Гэмтэл согог судлалын XXVI эрдмийн чуулганд “Acibadem Altunizade” сургуулийн профессор, гэмтэл согогийн мэс заслын эмч, АШУУИС-ийн зочин профессор Arel Gereli, “Management service”-ийн инженер, профессор Denis Siebert, “Memorial Spine center”-ийн эмч, профессор Onur Yaman, АШУУИС-ийн Монгол-Японы эмнэлгийн хөдөлгөөн засалч, профессор Ayako Sugano нар оролцож, сонирхолтой илтгэлүүд хэлэлцүүлэн туршлагаа хуваалцлаа.

Арга
хэмжээ
4.2



Арга
хэмжээ
4.4

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Салбар эмнэлгийн амбулаторийн 3 давхарт 46м² эмнэлзүйн ур чавдарын сургалтын өрөөг шинээр тохижуулан ур чадварын сургалт орж эхэллээ.



Арга
хэмжээ
6.1

Статистик тандалт судалгааны алба 2 жил тутамд “Монгол Улсад бүртгэгдсэн осол гэмтэл, гадны шалтгаант өвчлөл, нас баралтын таван жилийн байдал”-д тархвар зүйн судалгаа хийж ирсэн бөгөөд энэ онд хийгдсэн 4 дэх судалгаа болох “2019-2023 онд бүртгэгдсэн осол гэмтлийн тархвар зүйн судалгаа”-ны үр дүнгийн тайлан танилцуулах өдөрлөгийг ГССҮТ-ийн салбар эмнэлэгт зохион байгууллаа.



МУЗГ-ийн 2001 оны 224 дүгээр тогтоолд жил бүрийн 1 дүгээр сарын 2, 3 дахь долоо хоногт тодорхой сэдвийн дор осол гэмтлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулдаг. Энэхүү арга хэмжээний хүрээнд **“ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ -ТАНЫ ХАРИУЦЛАГААС”** аянг зохион байгуулсан. ГССҮТ байгууллагын үндсэн цахим хуудсаар дамжуулан хүүхдийг зам тээврийн осол, гэмтэл, хараа хяналт сул байдлаас болон бусад ахуйн хүрээний осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, яаралтай тохиолдолд авах хариу арга хэмжээ, хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх зэрэг зөвлөмж, мэдээлэл бүхий постер, зурагт хуудсуудыг цахим орчинд байршуулан **“ХҮҮХДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ -ТАНЫ ХАРИУЦЛАГААС”** аяныг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан.

Арга
хэмжээ
6.3



- Байгууллагын хэмжээнд эрүүл мэндийг дэмжин спортын гурван төрөлт тэмцээнийг амжилттай зохион байгуулсан.



Арга
ХЭМЖЭЭ
6.5



Арга
хэмжээ
6.7

Дохионы хэлний анхан шатны 2 өдрийн сертификаттай сургалтад сувилагч, тусгай мэргэжилтэн, цахим бүртгэгч, хөтөч зэрэг нийт 56 хүн хамрагдсан.



БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

ОРОН НУТГИЙН ЭМНЭЛГҮҮДЭД АЛСЫН ЗАЙНААС МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БАЙНА.

1	Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс телемедицин (цахим зөвлөн туслах үйлчилгээ)-гээр дамжуулан орон нутгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төв болон нэгдсэн эмнэлгүүдтэй хамтран гэмтлийн шалтгаантай, биеийн ерөнхий байдал маш хүнд үйлчлүүлэгчдэд яаралтай тусламж үйлчилгээг цаг алдалгүй, түргэн шуурхай үзүүлж байна. Орон зайн алслалтаас үл хамааран иргэд, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай, чанар хүртээмжтэй үзүүлэх чухал ач холбогдолтой энэхүү ажлын хүрээнд гэмтлийн шалтгаант өвчлөлийн оношийг тодруулах, эмчилгээний талаар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, алсын дуудлагын баг томилох, үйлчлүүлэгч тээвэрлэх зэрэг цогц үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж буй юм. 2024 онд 21 аймгаас нийт 150 удаагийн цахим зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна. 
2	ГССҮТөвийн хамт олон алсын дуудлагын баг орон нутагт эрүүл мэндийн яаралтай мэс заслын тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж байна. 2023 оны байдлаар нийт 110 удаагийн алсын дуудлага явж тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. 

3

Гэмтэл согогийн тусламж үйлчилгээ шаардлагтай үйлчлүүлэгчийг нисдэг тэргээр зөөвөрлөж тусламж үйлчилгээг цаг алдалгүй шуурхай үзүүлж байна. 2024 онд онгоцоор орон нутгаас нийт 55 тохиолдолд тусламж үйлчилгээг үзүүллээ.



Эмнэлгийн тоног төхөөрөмж

1

Mindray A7 -2ш Унтуулгийн аппаратыг хүлээн авч сургалт хийнэ. Үйл ажиллагаанд оруулсан.



2

Салбар эмнэлгэт мэс заслын микроскопи хүлээн авч тухай бүрт сургалт хийнэ. Үйл ажиллагаанд оруулсан.




3

Төв эмнэлэгт 3ш Зөөврийн харалттай C-ARM Рентген аппаратыг хүлээн авч ашиглалтад орууллаа.



4

Салбар эмнэлэгт Mindray брэндийн 10ш хяналтын монитор болон Төвийн хяналтын монитор суурилуулан ажиллагаанд оруулсан байна.



5

Төв эмнэлэгт зөөврийн зүрхний эхо болон Зөөврийн 3ш эхо аппарат авсан.




6

БАЙГУУЛЛАГЫН ОРЧИН НӨХЦӨЛ САЙЖРУУЛАХ

Засвар үйлчилгээ

1	Төвийн яаралтай тусламжийн тасгийн хүүхдийн цэгцэлгээний өрөө засаж тохижуулав 
2	Яаралтай хагалгааны эмч ажилчидад зориулсан ариун цэврийн өрөө шинээр байгуулсан. 

3	Салбар эмнэлгийн хагалгааны өндөр өртөгтийн өрөө гаргаж, засварлав.   
4	Салбар эмнэлгийн түлэнхийн тасагт вакум агааржуулалттай хагалгааны 2 блок, хувцас солих өрөө, бичиг хэргийн өрөө, ариун өрөө, техникийн өрөө, өвчтөн солилцох хэсэг байгуулав.   



5 Архивыг стандартад нийцүүлэн орц гарцыг нэмж төмөр хаалгатай болгон засварлаж, бичиг баримт хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн.



6 Салбар эмнэлгийн Түлэнхий тасагт хүчилтөрөгч,агаар, вакум 3 шугам татав.



7 Төв эмнэлгийн нэгдүгээр давхар В1 давхар хоорондын шат засварлав.



8 Салбар эмнэлгийн амбулаторид өлгүүр байгуулав.



9 Салбар эмнэлгийн яаралтай тусламжийн хэсэгт өлгүүр байгуулсан.



10 Салбар эмнэлгийн угаалгын хэсгийг засварлаж, тоног төхөөрөмжүүдийг суурьлуулав.



11 Төв эмнэлгийн амulatorийн чих хамар хоолойн эмчийн өрөө засварлав.



12 Салбар эмнэлгийн хагалгааны урсгалыг цэгцэлж хаалт хаалга хийв



13 Төв эмнэлгийн өргөтгөлийн хагалгааны 3 блок болон коридор засварлав.



14 Салбар эмнэлэгт тусгаарлах өрөө байгуулсан.



15 Салбар эмнэлгийн Сэргээн засах төвийн үүдэнд хувцас солих шкаф, металл вакум хаалт хийв.



16 Салбар эмнэлэгт Сэргээн засах спорт танхим төв байгуулав



17 Салбар эмнэлгийн түлэнхийн тасгийн бохир боолтын өрөөнд өгөх сорох агааржуулалтын тоноглол суурилуулж агаар сэлгэлтэй болгов.



18

Төв эмнэлгийн гадна гэрэлтүүлэг сайжруулан 4 цамхаг гэрэл байршуулав.



БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Д/Д	“ХҮҮХЭД –АЮУЛГҮЙ ОРЧИН” АЯН
	ХҮҮХЭД - АЮУЛГҮЙ ОРЧИН ГССҮТ-д 2022 оны байдлаар тогтооноос бага насны хүүхдийн хэргэлээс унах, гэмтэл тохиолдол нийт уналтаас үүдэлтэй эмсгийн 8.4% (2700)-ийг эзэлж байна. Зөвлөмж: - Бага насны хүүхдийг тоглоомын талбай дээр тоглуулж байх харах хяналт тавих - Уналт бэрхтэйгээ сэргийлж өвдөг, тохойны хамгаалалт зүүлгэх - Спортны хамгаалалт хэрэгсэл, хувцасыг нэг бүрэн өмсүүрэх ХҮҮХЭД - АЮУЛГҮЙ ОРЧИН ГССҮТ-д 2022 онд дугуйтай зорчиж байгаад 493 (11.4%) хүүхэд зам тээврийн осолд орж гэмтсэн байна. Зөвлөмж: - Хүүхдэд хамгаалалтын малгай, өвдөгөн хэрэглүүлэх - Хүүхдийг машины замаас хол тоглуулах - Хүүхдэд тавих хараа хяналтаа сайжруулах ХҮҮХЭД - АЮУЛГҮЙ ОРЧИН Сүүлийн 5 жилийн дунджаар 5-9 насны хүүхдийн дунд уналтын шалтгаант өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан: 1. Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдрч унах (45.4%) 2. Тоглоом ба спортын талбайн хэрэгсэлээс унах (14.1%) 3. Орноос унах (7.1%) 4. Шат гишгүүрээс унах (6.4%) 5. Нэг түвшнээс өөр түвшин рүү унах (5.4%) ХҮҮХЭД - АЮУЛГҮЙ ОРЧИН ГССҮТ-д 2022 онд 7.1% (2282) хүүхэд шат, гишгүүр дээр болон түүнээс унаж гэмтэл, бэртэл авсан байна. Зөвлөмж: - Шатанд баригд хийх - Бага насны хүүхэдтэй бол шатнаас унахаас сэргийлж шатны өмнө хаалт хийх - Гэрийн гадаах шат, гишгүүрийн ойролцоо гэрэлтүүлэг хийх
	ЭРҮҮЛ ЭРСДЭЛГҮЙ -ЦАГААН САР" аян Сар шинийн баяр ёслолын үед зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл, ахуйн хүрээний санаатай болон санамсаргүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээлэл сэрэмжлүүлэг, санамжийг АмбТ, ЯТТ-ийн хүлээлгийн танхимын телевизээр өдөрт 800-850, нийт 12,800 үйлчлүүлэгчид хүргэсэн. Мөн тус аянд ГССҮТ-ийн эмч, эмнэлгийн ажилтнууд нэгдэхийг уриалж идэвхтэй оролцсон.

“ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөтөлбөрийн хүрээнд бусад төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоо, зөвлөгөөг нийт 160 иргэдэд хүргэн ажилласан.



“Осол гэмтлээс сэргийлэх нь” өдөрлөгийн хүрээнд нийт 800 гаруй иргэдэд эрүүл мэндийн зөвлөгөө зөвлөмж өгөх, ясны сийрэгжилт, биеийн жингийн индекс, цусны даралт болон сахар тодорхойлох, сэтгэл зүйчийн зөвлөгөө, гэмтлийн дараах сэргээн засах эмчийн болон бусад мэргэжлийн эмч нарын үзлэг зөвлөгөө хүргэж ажиллаа.



Осол гэмтлийн шалтгаан, тэргүүлэх хүчин зүйлс, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл, ГССҮТ-ийн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношлогоо зэрэг үйлчилгээг нийт 627 хүргэн ажилласан байна.



“Эрсдэлгүй эрүүл орчныг хамтдаа” уриан дор өнгөрөгч бямба гарагт зохион байгуулагдсан “Автомашингүй өдөр-2024” нэгдсэн арга хэмжээнд төвийн эмч, сувилагч нар болон Нийгмийн эрүүл мэндийн алба оролцлоо.



“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИЙН ҮЗЭСГЭЛЭН 2024” нь 2024 оны 10 дугаар сарын 04-06-ний өдрүүдэд “Мишээл экспо” ОУУХТ-д зохион байгуулагдсан өдөрлөгт төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нар иргэд олон нийтэд эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн дэвшилтэт технологио танилцуулан, урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээллийг хүргэн ажилласан.



СХД, 105-р цэцэрлэгийн нийт 32 багш, ажилчдад зохион байгуулсан “Хүүхдийг ахуйн орчин дахь осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх” сургалт зохион байгуулав.



Нийслэлийн ерөнхий боловсролын 70-р сургуулийн ахлах ангийн 110 сурагчдад, 77-р сургуулийн 42 багш, ажилтнуудад “СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ СУРАЛЦАГЧИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” сургалтыг зохион байгуулав.



Хүүхдэд ээлтэй аюулгүй орчинг бүрдүүлэх, эрүүл дэмжлэгт орчинг бий болгох, ахуйн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, талаар зөвлөгөө мэдээлэлийг ХМЗТасаг, Түлэнхий нөхөн сэргээх мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлж буй 45 хүүхдүүд, эцэг эх, асран хамгаалагч, сахиуруудад хийсэн.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах ажлын хүрээнд НЕБ-ийн 70-р сургуулийн нийт 42 багш болон боловсролын ажилтнуудад “Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, Хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлэх, хүүхдийн асаргаа сувилгааны суурь чадамжийг дээшлүүлэх талаар сургалт зохион байгууллаа.



Яаралтай тусламж шаардлагатай өвчтөн, үйлчлүүлэгчийн амь тэнссэн үеийг зөв үнэлэх, уг байдалд хүргэх нэн аюултай эмгэгүүдийг илрүүлэх, эмнэлзүйн шийдвэр гаргах ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой сургалтанд төвийн нийт 240 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.



“Монголын гэмтэл согогийн эмч мэргэжилтнүүдийн холбоо”-ноос “Гэмтлийн шалтгаант толгойн мэс заслын өнөөгийн байдал” сэдэвт онол практикийн бага хурлыг амжилттай зохион байгууллаа.



Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн цусны явуулын багтай хамтран “Донор та амь тэтгэгч” өдөрлөгийг 2024 онд 2 удаа амжилттай зохион байгууллаа.



Төвийн Сувилахуйн албанаас сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дунд жил бүр зохион байгуулдаг “Нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээ” эрдэм шинжилгээний XXIV хурлыг амжилттай зохион байгуулж, сувилагч тусгай мэргэжилтнүүд туршлага солилцлоо.



Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүд энэ сарын 27-ны өдөр Төв аймгийн Батсүмбэр дэх “Ахмад настны үндэсний төв”-д ажиллаж, 182 орчим ахмад настанд эрүүл мэндийн үзлэг оношилгоо, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, сэтгэл зүйн зөвлөгөө, сувилахуйн тусламж үйлчилгээг цогцоор нь үзүүлээ.



Олон улсын сувилагч нарын өдөр”-ийг угтан Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс АШУҮИС-ийн Сувилахуйн сургуультай хамтран энэ сарын 03-ны өдөр “Багш шавийн эрдмийн уулзалт-2024” уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.



Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан өдгөө ес дэх жилдээ уламжлал болгон зохион байгуулж буй “Жаргалтай эх үрс” баярын өдөрлөг амжилттай боллоо.



Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сарын хүрээнд сургалт-өдөрлөг зохион байгуулж, ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэлээ.



Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс "Eejii.org" сангийн хамтын ажиллагааны дагуу 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн хоёр сарын хугацаанд Яаралтай тусламжийн тасаг, Амбулаторийн тасагт хөтөч, зөвлөн туслагчаар ажиллаа.



Төвийн Сэргээн засах эмчилгээний тасгаас энэ сарын 01, 02-ны өдрүүдэд нийт эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууддаа зориулсан “Сэтгэл зүйн өдөрлөг”-ийг төв болон салбар эмнэлэгт зохион байгууллаа.



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд Баянзүрх дүүргийн 28 дугаар хороонд байрлах “IGM” цэцэрлэгт хүрээлэнд 30 ширхэг монос модыг тарилаа.



Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс нийт ажилтнуудынхаа нийгмийн баталгааг хангах, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олныг бий болгох, ахуйн осол гэмтлээс хүүхдийг урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд 2020 оноос эхлэн нийслэлийн 94 дүгээр цэцэрлэгтэй хамтран ажиллаж буй билээ.



Гэмтэл согог судлалын үндэсний төвийн салбар эмнэлэгт эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон үйлчлүүлэгчдэд зориулсан сэтгэл заслын өрөөг иж бүрэн тохижуулж, ашиглалтад орууллаа.




ДЭМБ-аас жил бүрийн 11 дүгээр сард уламжлал болгон тэмдэглэдэг бичил биетний эсрэг мэдлэг олгох долоо хоногийн аянд Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нэгдлээ.



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

ГАДААД : Тайлант онд нийт гадаадын 10 эмнэлэгтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байна.Үүнд:

- БНСУ-ын Eunsung medical foundation Good hospitals эмнэлэг
- БНСУ-ын Сөүлийн их сургуулийн эмнэлэг
- БНСУ-ын Daedong I эмнэлэгтэй
- БНСУ-ын Бусаны их сургуулийн эмнэлэгтэй
- БНХАУ-ын Өвөр Монголын АУИС-ийн 2-р харъяа эмнэлэг
- ХОНКОНГ-ийн Матилда олон улсын эмнэлэг
- БНСУ-ын Yonsei Gunwoo эмнэлэгтэй
- ВЬЕТНАМ улсын Ханой хотын анагаах ухааны их сургуультай
- БНСУ-ын Chung-Ang их сургуулийн эмнэлэг
- БНСУ-ын Pureun эмнэлэгтэй



ДОТООД: Тайлант онд дотоодын 7 эрүүл мэндийн болон хувийн байгууллагтай хамтын ажиллааны гэрээ байгуулан ажиллаа.Үүнд:

- “Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв”
- ШШГЕГ-ын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг
- Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр анги
- Нийслэлийн хүүхдийн сэргээн засах төв

- Улаанбаатар төмөр замын төв эмнэлэг
- Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг
- “Монгол Хьюндай” эмнэлэг



Эх сурвалж: Гэмтэл согог судлалын үндэсний төв Ил тод байдлын ажилтан Э.Батдорж
Утас: 77117444-1 Цахим шуудан:Batdorj.e@gemtel.moh.gov.mn